



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН
СТАТИСТИКИЙН ХЭЛТЭС

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ

MONTHLY BULLETIN OF STATISTICS

2019/10



www.nso.mn govisumber.nso.mn www.1212.mn



ГАРЧИГ

- I. Нийгмийн байдал.....
- II. Нийгмийн даатгал, халамж.....
- III. Эрүүл мэнд
- IV. Гэмт хэрэг
- V. Үнэ.....
- VI. Төсөв.....
- VII. Хөдөө аж ахуй
- VIII. Аж үйлдвэр
- IX. Цаг уур.....
- Хавсралт.....



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал



I. Нийгмийн байдал


I.1 Ажил хайгч иргэд

Тайлант сарын эцэст Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэд 206, үүнээс ажил хайгч ажилгүй иргэдийн тоо 143 байгаагийн 75 нь эмэгтэйчүүд байна. Ажил хайгч ажилгүй иргэд өмнөх оны мөн үеэс 11 буюу 7.1 хувиар, өмнөх сараас 72 буюу 33.5 хувиар тус тус буурсан үзүүлэлттэй байна.

Аравдугаар сард Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газарт 59 ажлын байрны захиалга иржээ.

Тайлант сард 60 иргэн ажилд зуучлагдсаны 16 буюу 26.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Ажилд зуучлуулсан иргэд өмнөх оны мөн үеэс 3.2 хувиар буурсан болно.

Зураг I.1. Хөдөлмөр халамж, үйлчилгээний газарт бүртгүүлсэн ажил хайгч иргэн, жил бүрийн тайлант сарын эцэст




Ажил хайгч ажилгүй иргэдийг насны бүлгээр нь авч үзвэл 15-24 насны 44, 25-34 насны 45, 35-44 насны 30, 45-54 насны 18, 55 түүнээс дээш насны 6 иргэн байна.

I.2 Ердийн хөдөлгөөн

Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээгээр 2019 оны эхний 10 сарын байдлаар 361 эх амаржиж, 366 хүүхэд мэндэлсэн нь өмнөх оны мөн үеэс амаржсан эхийн тоо 31 буюу 7.9 хувиар, төрсөн хүүхдийн тоо 27 буюу 6.9 хувиар тус тус буурсан байна.

Нас баралт 65, бүртгүүлсэн гэр бүл 62, цуцалсан гэр бүл 21 байгаа нь өмнөх оны мөн үеэс цуцалсан гэр бүл 6 буюу 40.0 хувиар өсч, нас баралт 8 буюу 10.9 хувиар, бүртгүүлсэн гэр бүл 9 буюу 15.1 хувиар буурсан үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд 8 хүүхэд үрчлэгдсэн. Шилжилт хөдөлгөөний мэдээгээр 314 хүн шилжин ирсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал 181 хүнээр буюу 36.6 хувиар буурсан.

Зураг I.2. Төрсөн хүүхдийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар





II. Нийгмийн даатгал, халамж

II.1 Нийгмийн даатгал

2019 оны эхний 10 сарын байдлаар нийгмийн даатгалын сангийн орлого 9470.0 сая төгрөг, зарлага 9754.1 сая төгрөг болсон байна.

Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөний биелэлт 139.1 хувьтай, зарлагын гүйцэтгэл 98.3 хувьтай байна.

II.2 Нийгмийн халамж

Нийгмийн халамжийн сангаас 2019 оны эхний 10 сарын байдлаар 6815 хүнд 1739.6 сая төгрөгийн нийгмийн халамжийн үйлчилгээ үзүүлсэн нь өмнөх оны мөн үеэс нийгмийн халамж хүртэгсэд 405 хүн буюу 6.3 хувиар, олгосон тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, тусламж 97.5 сая төгрөг буюу 5.9 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


✓ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжид 2102 хүн хамруулж 1038.1 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 32 хүн буюу 1.5 хувиар буурч, олгосон тэтгэвэр, тэтгэмж 51.7 сая төгрөг буюу 5.2 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

✓ Нийгмийн халамжийн үйлчилгээ хөнгөлөлт, тусламжид 4713 хүн хамруулж 701.5 сая төгрөг олгосон нь өмнөх оны мөн үеэс 437 хүн буюу 10.2 хувиар, олгосон халамж үйлчилгээ, хөнгөлөлт, тусламж 45.8 сая төгрөг буюу 7.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

II.3 Дундаж цалин

Аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2019 оны 10 дугаар сарын мэдээгээр 217 байгууллагын 5906 даатгуулагч иргэн, үүнээс 679 нь сайн дурын даатгуулагч байна. Ажиллагсдын дундаж цалинг аж ахуйн нэгж байгууллагын хариуцлагын хэлбэрээр авч үзвэл төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой 11 аж ахуйн нэгж, байгууллагын 424 даатгуулагчийн дундаж цалин 976.7 мянган төгрөг, төсөвт 55 байгууллагын 1804 даатгуулагчийн дундаж цалин 972.1 мянган төгрөг, 2 Хувьцаат Компаний 654 даатгуулагчийн дундаж цалин 1654.2 мянган төгрөг, 125 ХХКомпаний 2170 даатгуулагчийн дундаж цалин 966.9 мянган төгрөг, бусад 24 аж ахуйн нэгж байгууллагын 175 даатгуулагчийн дундаж цалин 600.7 мянган төгрөг боллоо.

Зураг II.1. Нийгмийн даатгалын даатгуулагчийн тоо, 2019 оны эхний 10 сарын байдлаар



III. Эрүүл мэнд




Эрүүл мэндийн газраас эрхлэн гаргадаг мэдээгээр 2019 оны эхний 10 сарын байдлаар 370 эх амаржиж, 2018 оны мөн үетэй харьцуулахад 26 буюу 6.6 хувиар буурсан байна.

Амьд төрсөн хүүхэд 372 үүнээс 196 нь хүү, 176 нь охин байна. Өмнөх оны мөн үеэс амьд төрсөн хүүхэд 23 буюу 5.8 хувиар буурсан байна.


0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл 4, 1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл болон эхийн эндэгдэл бүртгэгдээгүй.

Зураг III.1. Амаржсан эх, амьд төрсөн хүүхэд, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Халдварт өвчин эхний 10 сарын байдлаар 141 буюу 10000 хүн амд 78.9 хүн байгаа нь өмнөх оны мөн үеэс 34.1 хувиар буурсан байна.


Зураг III.2.Нас баралт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Он гарсаар давхардсан тоогоор 79280 хүнд амбулаторийн үзлэг хийсэн нь өмнөх оны мөн үеэс 14127 хүнээр буюу 14.2 хувиар, 4007 өвчтөн эмчлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 239 хүнээр буюу 5.6 хувиар тус тус буурсан байна.

2019 оны эхний 10 сарын байдлаар түргэн тусламжийн дуудлага 4830 бүртгэгдсэн байна.

Зураг III.3.Амьгүй төрсөн хүүхэд болон нялхсын эндэгдэл, жил бүрийн эхний 10 сарын байдлаар




IV. Гэмт хэрэг

Аймгийн Цагдаагийн хэлтсийн мэдээгээр 2019 оны эхний 10 сарын байдлаар 128 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 10 буюу 7.2 хувиар буурсан үзүүлэлттэй байна.



Зураг IV.1.Бүртгэгдсэн гэмт хэргийн тоо, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Өмнөх оны мөн үеэс нийт гэмт хэргийн тоо буурахад хүний эрүүл мэндийн халдашгүй байдлыг эсрэг гэмт хэрэг буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Илрээгүй гэмт хэрэг 55 байгаа нь өмнөх оны мөн үеэс 3.8 хувиар өссөн. Гэмт хэрэг илрүүлэлтийн хувь 51.8 болсон нь өмнөх оны мөн үеэс 8.4 пунктээр буурсан үзүүлэлттэй байна.

Гэмт хэргийн улмаас 71 хүн гэмтсэн нь өмнөх оны мөн үеэс 17.4 хувиар буурсан байна.


Зураг IV.2.Гэмт хэргийн ангилал, жил бүрийн эхний 10 сарын байдлаар



Гэмт хэргийн улмаас учирсан хохирол эхний 10 сарын байдлаар 240.8 сая төг, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 85.5 сая төг болж, өмнөх оны мөн үеэс учирсан хохирлын хэмжээ 294.2 сая төгрөгөөр буюу 2.2 дахин, нөхөн төлүүлсэн хохирлын хэмжээ 149.2 сая төгрөг буюу 2.7 дахин буурсан үзүүлэлттэй байна.

2019 оны эхний 10 сарын байдлаар давхардсан тоогоор 701 хүн эрүүлжүүлэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 118 хүнээр буюу 20.2 хувиар өссөн байна.

Зураг IV.3.Гэмт хэргийн улмаас гэмтсэн, нас барсан хүний тоо жил бүрийн эхний 10 сарын байдлаар



V. Хэрэглээний үнийн индекс

Хэрэглээний үнийн индекс гэдэг нь хэрэглэгчдийн худалдаж авсан бараа, үйлчилгээний нэр төрлөөр өөрчлөлтгүй тогтвортой байхад үнэ дунджаар хэрхэн өөрчлөгдөж буйг хэмждэг үзүүлэлт юм.



Хэрэглээний бараа, үйлчилгээний үнэ аймгийн хэмжээнд 2019 оны 10 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.1 хувиар, 2018 оны жилийн эцсээс 5.6 хувиар, өмнөх сараас 0.2 хувиар өсч байна.

Хүснэгт V.1.Хэрэглээний үнийн индекс, 2019 оны 10 дугаар сард, бүлгийн дүнгээр

Бараа үйлчилгээний бүлэг	$\frac{2019.X}{2018.X}$	$\frac{2019.X}{2018.XII}$	$\frac{2019.X}{2019.IX}$
Ерөнхий индекс	106.1	105.6	100.2
Хүнсний бараа, ундаа, ус	111.7	111.9	98.5
Согтууруулах ундаа, тамхи	108.0	105.3	100.9
Хувцас, бөс бараа, гутал	106.5	106.5	102.4
Орон сууц, ус, цахилгаан, түлш	104.0	103.7	100.1
Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа	106.7	106.3	100.5
Эм, тариа, эмнэлгийн үйлчилгээ	100.7	100.7	100.0
Тээвэр	99.6	97.8	100.0
Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ	99.1	99.1	100.0
Амралт, чөлөөт цаг, соёлын бараа, үйлчилгээ	100.2	100.2	100.0
Боловсролын үйлчилгээ	111.6	111.6	100.0
Зочид буудал, нийтийн хоол, дотуур байр	100.5	100.5	100.0
Бусад бараа, үйлчилгээ	100.7	104.7	99.6

Эх үүсвэр: Үндэсний статистикийн хорооны сарын мэдээ



VI. Төсөв санхүү

2019 оны эхний 10 сарын байдлаар орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөө 12252.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 13349.5 сая төгрөг болж 108.9 хувийн биелэлттэй байна.

Аймгийн төсвийн нийт зарлагын төлөвлөгөө 14084.8 сая төгрөг, гүйцэтгэлээр 12785.5 сая төгрөг болж 90.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

2019 оны эхний 10 сарын байдлаар авлагын үлдэгдэл 51.3 сая төгрөг, өглөгийн үлдэгдэл 239.3 сая төгрөг байна.

Зураг VI.1. Орон нутгийн төсвийн орлого, зарлага, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр




VII. Мал аж ахуй, газар тариалан


Аймгийн хэмжээнд 2019 онд төллөвөл зохих нийт 203579 хээлтэгчийн 157898 буюу 77.6 хувь нь төллөсөн байна. Төл бойжилт 98.4 хувьтай байна. 2019 оны эхний 10 сарын байдлаар 2839 толгой том мал зүй бусаар хорогдсон нь өмнөх оны мөн үеэс 9.2 дахин бага байна. Том малын зүй бус хорогдлын 22.6 хувь нь хээлтэгч мал байна.



Зураг VII.1.Төллөсөн хээлтэгч, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, толгойгоор



Зураг VII.2.Хорогдсон хээлтэгч, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, толгойгоор




2019 оны байдлаар аймгийн хэмжээнд нийт 49.8 га талбайд төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалсан байна. Тариалсан талбайн мэдээг өмнөх оны мөн үетэй харьцуулбал төмс 2.74 га талбайгаар буюу 17.0 хувиар, хүнсний ногоо 5.82 га талбайгаар буюу 44.8 хувиар тэжээлийн ургамал 1.0 га талбайгаар буюу 8.3 хувиар нэмэгдсэн байна.

Зураг VII.3.Тариалсан талбай, 2018, 2019 оны байдлаар, га



Ургац хураалтын эцсийн мэдээгээр аймгийн хэмжээнд 18.0 га талбайгаас 128.5 тн төмс, 17.5 га талбайгаас 145.4 тн хүнсний ногоо, 10.0 га талбайгаас 50.0 тн тэжээлийн ургамал хураасан нь өмнөх оны мөн үеэс, төмс хураалт 34.1 хувиар, тэжээлийн ургамал 17.1 хувиар, хүнсний ногоо 11.2 хувиар өссөн байна.

Зураг VII.4.Хураасан ургац, жил бүрийн 10 дугаар сарын байдлаар, тн



VIII. Аж үйлдвэр

Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэл 2019 оны эхний 10 сарын байдлаар 39.5 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 1.5 тэрбум төгрөг буюу 4.0 хувиар, оны үнээр 45.2 тэрбум төгрөгийн борлуулалт хийгдсэн нь өмнөх оны мөн үеэс 4.4 тэрбум төгрөг буюу 10.8 хувиар өссөн байна.

Шивээ-Овоо ХК нийт бүтээгдэхүүний 92.7 хувь буюу 36.6 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийт борлуулалтын 96.0 хувь буюу 43.4 тэрбум төгрөгийн бүтээгдэхүүн борлуулсан байна.

Зураг VIII.1. Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл, салбараар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр



IX. Цаг агаар 10 дугаар сард:

Хур тундас: 11, 18, 27-ны өдрүүдэд бороо орж, нийт 0.3 мм тунадастай.

Салхи: Энэ сард ихэнх хугацаанд салхи 5-10 м/сек, зарим үед 11-16 м/сек салхитай байв.

Агаарын температур: Агаарын дундаж температур нэгдүгээр арав хоног, хоёр ба гуравдугаар арав хоногийн сүүлээр 3-8 градус дулаан, бусад хугацаанд 1-6 градус хүйтэн, өдөртөө нэг ба хоёрдугаар арав хоногийн дундуур болон сүүлээр 12-17 градус дулаан бусад үед 4-9 градус дулаан байв.


АРВАННЭГДҮГЭЭР САРЫН ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

Говь сүмбэр аймгийн нутгаар агаарын температурын сарын дундаж нь 1-6 градус хүйтэн байдаг бөгөөд энэ сард олон жилийн дунджаас 0.5-1.0 градусаар дулаан байх төлөвтэй байна. Нэгдүгээр арав хоногийн эхээр шөнөдөө 9-14 градус хүйтэн, өдөртөө 3-8 градус дулаан байна. Нэгдүгээр арав хоногийн сүүлчээр бага зэрэг хүйтэрнэ. Хоёр дугаар арав хоногийн сүүлийн хагаст шөнөдөө 14-19 градус, өдөртөө 0-5 градус хүйтэн байна. Гуравдугаар арав хоногийн сүүлчээр шөнөдөө 20-25 градус, өдөртөө 8-13 градус хүйтэн байх төлөвтэй. Энэ сард орох хур



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

тунадасны хэмжээ нь олон жилийн дунджийн орчим цас орох төлөвтэй байна. Нэгдүгээр арав хоногийн сүүлчээр хоёрдугаар арав хоногийн дунд үеэр нутгийн зарим хэсгээх бага зэргийн цас орох төлөвтэй. Салхи нэгдүгээр арав хоногийн дунд болон сүүлчээр мөн хоёрдугаар арав хоногийн дунд үеэр 16-18м/с хүрч шороон болон цасан шуурга шуурах төлөвтэй.





ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	Хэмжих нэгж	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I - X}{2018 I - X} \%$
Нийгмийн статистик				
Амьд төрсөн хүүхэд, Эрүүл мэндийн газрын мэдээгээр	хүүхэд	395	372	94.2
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	хүн	154	143	92.9
Халдварт өвчнөөр өвчлөгсөд	хүн	214	141	65.9
Бүртгэгдсэн гэмт хэрэг	хүн	138	128	92.8
Эдийн засгийн статистик				
Орон нутгийн төсвийн орлого	сая.төг	16977.4	13349.5	78.6
Орон нутгийн төсвийн зарлага	сая.төг	11882.2	12785.5	107.6
Авлага	сая.төг	66.2	51.3	77.5
Өглөг	сая.төг	99.8	239.3	239.8
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт	сая.төг	37924.6	39450.6	104.0
Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн борлуулалт	сая.төг	40762.0	45181.8	11.8
Төллөсөн хээлтэгч	толгой	141843	157898	111.3
Гарсан төл	толгой	142803	158476	111.0
Хорогдсон төл	толгой	21605	2567	11.9
Бойжсон төл	толгой	121198	155909	128.6
Том малын зүй бусын хорогдол	толгой	30675	641	2.1



I.1 АЖЛЫН БАЙРНЫ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн 10 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2018 X	2019 X	$\frac{2019 X}{2018 X} \%$
Ажил хайгч иргэд, сарын эцэст	217	206	94.9
Үүнээс: эмэгтэй	129	115	89.1
Ажил хайгч ажилгүй иргэд, сарын эцэст	154	143	92.9
Үүнээс: эмэгтэй	91	75	82.4
Ажлын байрны захиалга	83	59	71.1
Ажилд зуучлагдсан иргэд	63	60	95.2
Үүнээс: эмэгтэй	30	16	53.3

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

I.2 ЕРДИЙН ХӨДӨЛГӨӨНИЙ ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлтүүд	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$
Амаржсан эх	392	361	92.1
Төрсөн хүүхэд	393	366	93.1
Үрчлэгдсэн хүүхэд	6	8	133.3
Бүртгүүлсэн гэр бүл	73	62	84.9
Цуцалсан гэр бүл	15	21	140.0
Нас баралт	73	65	89.0
Шилжин ирсэн	495	314	63.4

Эх үүсвэр: Улсын бүртгэлийн хэлтсийн мэдээ

II.1 НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО, ЗАРЛАГА, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сангийн төрөл	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$
НД-ын сангийн орлого, сая.төг	8 481.2	9 470.0	116.6
НД-ын сангийн зарлага, сая.төг	8 776.9	9 754.1	111.1

Эх үүсвэр: Нийгмийн даатгалын хэлтсийн мэдээ

II.2 НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНД ХАМРАГДСАН ХҮН, ОЛГОСОН ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-X		2019 I-X		$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$	
	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн	Хүн	Мөнгөн дүн
Нийгмийн халамжийн сангийн дүн	6 410	1 642.1	6 815	1 739.6	106.3	105.9
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	2 134	986.4	2 102	1 038.1	98.5	105.2
Халамжийн тэтгэвэр	251	344.8	259	399.2	103.2	115.8
Нөхцөлт мөнгөн тэтгэмж	1 883	641.6	1 843	638.9	97.9	99.6
Нийгмийн халамжийн үйлчилгээ болон хөнгөлөлт тусламж	4 276	655.7	4 713	701.5	110.2	107.0
Ахмад настнуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	1 738	210.7	1 919	212.5	110.4	100.9
Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	271	49.1	331	49.4	122.1	100.6



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

Нийгмийн халамжийн үйлчилгээ	697	79.5	831	90.0	119.2	113.2
Нийгмийн халамжийн хөнгөлөлт, нөхцөлт тусламж мөнгөн тусламж	294	139.0	317	164.4	107.8	118.3
Алдар цолтой ахмадуудад үзүүлсэн хөнгөлөлт, тусламж	6	8.7	7	12.3	116.7	141.4
Алдарт эхийн одонтой эхчүүдэд үзүүлэх мөнгөн тусламж	1 270	168.7	1 308	172.9	103.0	102.5

Эх үүсвэр: Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын мэдээ

III.1 ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I - X}{2018 I - X} \%$
Төрсөн эх	396	370	93.4
Амьд төрсөн хүүхэд	395	372	94.2
Эрэгтэй	200	196	98.0
Эмэгтэй	195	176	90.3
Амьгүй төрсөн хүүхэд	1	3	300.0
Нийт нас баралт	54	51	94.4
Эмнэлгийн нас баралт	9	10	111.1
Хоног болоогүй нас баралт	3	3	100.0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	1	4	400.0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0	*
Эмчлэгдсэн өвчтөн	4 246	4 007	94.4
Амбулаторийн үзлэг	92 407	79 280	85.8
Халдварт өвчин	214	141	65.9

Эх үүсвэр: Эрүүл мэндийн газрын мэдээ

IV.1 ЭРҮҮГИЙН БОЛОН ХЭВ ЖУРМЫН НӨХЦӨЛ БАЙДЛЫН МЭДЭЭ, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, төрлөөр

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I - X}{2018 I - X} \%$
Бүртгэгдсэн гэмт хэрэг	138	128	92.8
Хүний амь бие эрүүл мэндийн эсрэг	76	59	77.6
Өмчлөх эрхийн эсрэг	39	46	117.9
Нийгмийн аюулгүй байдлын эсрэг	3	3	100.0
Тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг	12	11	91.7
Олон нийтийн аюулгүй байдал ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг	2	2	100.0
Авилгын эсрэг гэмт хэрэг	5	5	100.0
Бусад гэмт хэрэг	1	2	200.0
Гэмт хэрэгт холбогдогсад	96	85	85.5
15 хүртэлх насны	1	2	200.0
16-34 насны	56	45	80.4
35 ба түүнээс дээш насны	39	38	97.4
Боловсрол – Дээд	19	11	57.9
Боловсрол - Тусгай дунд	8	1	12.5
Боловсрол – Бүрэн дунд	32	33	97.0
Боловсрол – Бүрэн бус дунд	22	23	104.5
Боловсрол – Бага	8	9	112.5
Боловсролгүй	7	8	114.3
Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн	23	19	82.6
Ажилгүй иргэд үйлдсэн	54	36	66.7



Говьсүмбэр аймгийн нийгэм, эдийн засгийн байдал

Эмэгтэй хүн оролцсон	13	11	84.6
Хүүхэд оролцсон	4	2	50.0
Бүлгээр үйлдсэн	8	5	62.5
Согтуугаар үйлдсэн	58	44	75.9
Гэмт хэргийн гаралт, нөхцөл байдал	138	128	92.8
Гудамж талбайд	40	29	72.5
Гэмт хэргийн улмаас нас барсан	5	7	140.0
Гэмт хэргийн улмаас гэмтсэн	86	71	82.5
Учирсан хохирол / сая.төг /	535.0	240.8	45.0
Нөхөн төлүүлсэн хохирол / сая.төг /	234.7	85.5	36.4

Эх үүсвэр: Цагдаагийн хэлтсийн мэдээ

VI.1 ТӨСВИЙН ОРЛОГО, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$
Нийт орлого	16 977.4	13 349.5	78.6
Урсгал орлого	4 259.3	5 383.7	126.4
Татварын орлого	3 854.5	4 848.1	125.8
Татварын бус орлого	404.8	535.6	132.3
Тусламжийн орлого	12 718.1	7 965.7	62.6

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.2 ТӨСВИЙН ЗАРЛАГА, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$
Нийт зарлага	11 882.2	12 785.5	107.6
Урсгал зардал	10 865.9	11 547.9	106.3
Хөрөнгийн зардал	1 016.3	1 237.6	121.8

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VI.3 ТӨСВИЙН ӨГЛӨГ, АВЛАГЫН ҮЛДЭГДЭЛ, үзүүлэлтүүдээр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$
Авлага	66.2	51.3	77.5
Өглөг	99.8	239.3	239.8
Төсөвт байгууллагын тоо	49	48	97.9
Төсөвт байгууллагын ажиллагсад	783	783	100.0

Эх үүсвэр: Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэдээ

VII.1 МАЛ ТӨЛЛӨЛТ, эх малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$
Бүгд	141 843	157 898	111.3
Ингэ	140	126	90.0
Гүү	2 984	4 081	136.8
Үнээ	3 361	3 725	110.8
Эм хонь	71 775	82 042	114.3
Эм ямаа	63 583	67 924	106.9



VII.2 ТӨЛЛӨСӨН ХЭЭЛТЭГЧ сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$
Дүн	141 843	157 898	111.3
<u>Баянтал</u>	26 374	26 463	100.3
<u>Сүмбэр</u>	98 673	111 208	112.7
<u>Шивээговь</u>	16 796	20 227	120.4

VII.3 БОЙЖСОН ТӨЛ, төлийн төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$
Бүгд	121 198	155 909	128.6
Ботго	134	116	86.6
Унага	2 776	4 003	144.2
Тугал	3 143	3 681	117.1
Хурга	63 687	81 123	127.4
Ишиг	51 458	66 986	130.2

VII.4 БОЙЖСОН ТӨЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$
Дүн	121 198	155 909	128.6
<u>Баянтал</u>	25 117	26 323	104.8
<u>Сүмбэр</u>	78 910	109 378	138.6
<u>Шивээговь</u>	17 171	20 208	117.7

VII.5 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$
Бүгд	30 675	2 839	9.3
Тэмээ	7	9	128.6
Адуу	1 151	79	6.9
Үхэр	1 615	66	4.1
Хонь	11 289	1 108	9.8
Ямаа	16 613	1 577	9.5

VII.6 ЗҮЙ БУСААР ХОРОГДСОН ТОМ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I-X}{2018 I-X} \%$
Дүн	30 675	2 839	9.3
<u>Баянтал</u>	2 250	370	16.4
<u>Сүмбэр</u>	27 948	2 366	8.5
<u>Шивээговь</u>	477	103	21.6



VII.7 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, малын төрлөөр, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Төрөл	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I - X}{2018 I - X} \%$
Бүгд	6 369	641	10.1
Тэмээ	1	3	300.0
Адуу	291	21	7.2
Үхэр	335	16	4.8
Хонь	2 130	293	13.8
Ямаа	3 612	308	8.5

VII.8 ХОРОГДСОН ХЭЭЛТЭГЧ МАЛ, сумдаар, жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Сумд	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I - X}{2018 I - X} \%$
Дүн	6 369	641	10.1
Баянтал	366	16	4.4
Сүмбэр	5 878	605	10.3
Шивээговь	125	20	16.0

VIII.1 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлт жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I - X}{2018 I - X} \%$
Нийт	37 924.6	39 450.6	104.0
Нүүрс олборлолт	36 071.0	36 570.8	101.4
Боловсруулах үйлдвэр	96.3	208.8	216.8
Цахилгаан, дулааны эрчим хүч	1 757.4	2 670.9	152.0

VIII.2 Аж үйлдвэрийн бүтээгдэхүүний борлуулалт, жил бүрийн эхний 10 сарын байдлаар, сая төгрөгөөр

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I - X}{2018 I - X} \%$
Нийт	40 762.0	45 181.8	110.8
Нүүрс борлуулалт	39 045.4	43 374.1	111.1
Боловсруулах үйлдвэр	84.1	67.2	79.9
Цахилгаан, дулаан эрчим хүч	1 632.4	1 740.5	106.6

VIII.3 Уул уурхайн салбарын бүтээгдэхүүний үзүүлэлтүүд, Шивээ-Овоо ХК жил бүрийн эхний 10 сарын байдлаар

Үзүүлэлт	2018 I-X	2019 I-X	$\frac{2019 I - X}{2018 I - X} \%$
Нүүрс борлуулалт /үнийн дүнгээр, сая.төг/	39 045.4	43 374.1	111.1
Нүүрс олборлолт /үнийн дүнгээр, сая.төг/	36 071.0	36 570.8	101.4
Нүүрс гаргалт /биет хэмжээ, мян.тн/	1 575.8	1 618.5	102.7
Ажиллагсад	556	554	99.6



Е-майл хаяг:

govisumber@nso.mn

Вэб хаяг:

govisumber.nso.mn

Мэдээллийн сангийн хаяг:

www.1212.mn

Утас:

70543222, 70543017